



ДОРНОД АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/34

Чойбалсан

Хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1, 12.1.4, 13.7, 24.6.4 дэх заалтууд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/668 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:


1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шаардлагатай эмийг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрх сумын эрүүл мэндийн төвүүдэд нийлүүлэх хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Баталсан хуваарийн дагуу түгээлт хийж, хэрэглээнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Ахлах нягтлан бодогч Б.Батцэцэг, Эмийн чанар, аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн Х.Эрдэнэцэцэг нарт даалгасугай.

3. Нийлүүлэгдсэн эм бэлдмэлийг нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журмын дагуу хөрөнгийн бүртгэлд авч, хадгалалт, зарцуулалт, түгээлтэд хяналт тавьж ажиллахыг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс /Ч. Оюунтунгалаг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч. ОЮУНАА

